

- 1.13. Холбоо нь Монгол улсад уулын спортыг хөгжүүлэх, энэхүү спорттой холбоотой аливаа үйл ажиллагааг зохион байгуулах албан ёсны удирдах төв байгууллага юм.
- 1.14. Холбооны үйл ажиллагаанд улс төрийн нам, бусад байгууллага, хувь хүн, гадаадын болон олон улсын байгууллага хөндлөнгөөс оролцох, нөлөөлөхийг хориглоно.
- 1.15. Холбооны үйл ажиллагаа нь яс үндэс, гарал үүсэл, арьс өнгө, үзэл бодол, хэл яриа, алдар цолоор ялгаварлан гадуурхасан шинжтэй байж болохгүй.

ХОЁР. ХОЛБООНЫ ЗОРИЛГО

- 2.1. Холбооны зорилго нь Монгол улсад уулын спортыг хөгжүүлэх, түгээн дэлгэрүүлэх замаар бүх нийтийн хүртээл болгох, уулын спортын хөгжлийг олон улсын түвшинд хүргэх, дэлхийн тавцанд гаргах, амжилтаа ахиулж, улс орныхоо нэр хүндийг сурталчилах, авьяаслаг, ур чадвартай тамирчин, дасгалжуулагч, шүүгчдийг бэлтгэж, дэмжихэд чиглэнэ.
- 2.2. Олон улс, тив, дэлхий, бүс нутгийн хэмжээнд өрсөлдөхүйц тамирчдыг тасралтгүй бэлтгэнэ.

ГУРАВ. ХОЛБООНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЧИГЛЭЛ

- 3.1. Холбоо нь энэхүү дүрмийн 2 дугаар зүйлд заасан зорилгоо хэрэгжүүлэхийн тулд дараах чиглэлээр үйл ажиллагаа явуулна. Үүнд:
 - 3.1.1. Холбоо уулын спортын эрсдэл аюулгүй байдлын асуудлаар бодлогоор хангаж мэргэжил, арга зүйн дэмжлэг үзүүлж ажиллана.
 - 3.1.2. Уулын спортыг сонирхогч, хичээллэгч, дэмжигчдийн үйл ажиллагааг нэгтгэн зохион байгуулах, удирдан чиглүүлэх;
 - 3.1.3. Уулын спортын чиглэлээр эрдэм шинжилгээ, судалгааны ажил явуулах санал санаачлагыг хөхүүлэн дэмжих, зохион байгуулах;
 - 3.1.4. Уулын спортыг хөгжүүлэх, энэ спортыг бүх нийтийн хүртээл болгох талаар санал боловсруулж, холбогдох эрх бүхий байгууллагад тавьж шийдвэрлүүлэх;
 - 3.1.5. Уулын спортыг бүх нийтэд, ялангуяа хөдөө орон нутагт сурталчилах, түгээн дэлгэрүүлэх, хүүхэд багачуудын сонирхлыг улам бүр нэмэгдүүлэх, энэ чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг бусад байгууллагатай хамтран ажиллах, улсын болон бүс нутгийн хэмжээнд уралдаан, тэмцээн, олон нийтийн хамарсан бусад арга хэмжээ зохион байгуулах;
 - 3.1.6. Уулын спортыг бүх нийтэд таниулан сурталчилахдаа байгаль эрх хайрлах, хүндэтгэх, орон нутгийн ёс заншлыг эрхэмлэн дээдлэх соёл, арга барилыг хамтад нь сурталчилах;
 - 3.1.7. Олон улсын болон бүс нутгийн чанартай тэмцээн уралдаанд үндэсний шигшээ багийг өндөр түвшинд бэлтгэн оролцуулах замаар тэдний ур чадвар, туршлагыг нэмэгдүүлэх;
 - 3.1.8. Дасгалжуулагч, шүүгчид, тамирчдыг мэргэжил, мэдлэг, ур чадварыг дээшлүүлэхэд дэмжлэг үзүүлэх, тэднийг гадаадын болон дотоодын сургалтад тогтмол хамруулж байх;
 - 3.1.9. Тамирчид, дасгалжуулагч, шүүгч нарын ажлын нөхцөл, эдийн засгийн баталгааг хангахад дэмжлэг үзүүлэх, тэдгээрийн хууль ёсны эрх ашгийг хамгаалах;